



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 6.1, 6.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Газрын албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний ахлагч:	багийн Д.Ганболд	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүн:	С.Туул	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга
	Б.Энхцэцэг	Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн дарга
	О.Нямбат	Бодлогын баримт бичгийн тайлан, тогтоол шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн


Нарийн бичгийн дарга: Ш.Ундармаа Хүний нөөц, ёс зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний багийн үнэлсэн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн үнэлгээний 85-100 оноог “Маш сайн”, 70-85 хүртэл оноог “Хэвийн”, 70 хүртэл оноог “Хангалтгүй” үнэлгээний ангилалд хамруулан “Маш сайн” үнэлгээнд нэг сарын үндсэн цалингийн 100 хүртэл хувиар, “Хэвийн” үнэлгээнд нэг сарын үндсэн цалингийн 50 хүртэл хувиар тооцон урамшуулсугай.

3. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлж баталгаажуулан, эхний хагас жилийн тайланг 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор, сүүлийн хагас жилийн тайланг 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор үнэлгээний багт хүлээлгэн өгөхийг нэгжийн дарга нарт даалгасугай.

4.Нэгжийн дарга нарын баталгаажуулсан албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн эхний хагас жилийн үнэлгээг 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор, сүүлийн хагас жилийн үнэлгээг 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор хянаж, дүгнэж баталгаажуулан, санал, зөвлөмжийн хамт танилцуулахыг үнэлгээний баг /Д.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ